



## МҮХАҮТ-ЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БА НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

МҮХАҮТ-ын Удирдах зөвлөлийн 2017  
оны ... дугаар сарын .... -ний өдрийн хурлын  
..... тоот тогтоолоор батлав.

## **ЭРХЭМ ЗОРИЛГО**

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

## **АЛСЫН ХАРАА**

МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

## **ҮНЭТ ЗҮЙЛ**

### **- Чадварлаг, эвсэг хамт олон**

Мэдлэг, боловсрол, ур чадвартай, харилцан бие биенээ хүндэтгэж, сэтгэл гарган, зөв хандлагаар, санаачлагатай ажиллах хамт олон

### **- Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа**

Үр дүнд суурилсан ойлголцол ба итгэлцэлийг эрхэмлэж тогтвортой, үр дүнтэй, оролцоотой хамтын ажиллагааг хөгжүүлэх

### **- Үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ**

Эрэлт, хэрэгцээг урьдчилан харж, судлан, төлөвлөж, үйлчлүүлэгч харилцагчдад чанартай, сэтгэл, ханамжтай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох

### **- Ёс зүйт үйл ажиллагаа**

Хурдан, шуурхай, уян хатан, санаачлага гарган үнэнч шударгаар ил тод оролцогч талуудтай үр дүнтэй, хариуцлагатай ажиллах

### **- Манлайлал**

Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн томоохон төлөөлөгч болж санаачлагатай, оролцоотой, тогтвортой хөгжлийн хурдасгагч хүч болон хүртээмжтэй ажиллах

## **2017 ОН – ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ ЖИЛ**

## **ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД**

- Стратегийн зорилт 1:** Бизнесийн орчныг сайжруулахад бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, төр хувийн хэвшлийн хэлэлцлийн тогтолцоог бүрдүүлэх
- Стратегийн зорилт 2:** Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах
- Стратегийн зорилт 3:** Гишүүд ба бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлэх, урамшуулах
- Стратегийн зорилт 4:** Бизнесийн олон талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, талуудын харилцан ашигтай түншлэлийг бэхжүүлэх
- Стратегийн зорилт 5:** Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөнд мэдрэмжтэй хандаж гишүүд, бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг үнэ цэнэтэй мэдлэг, мэдээллээр хангах
- Стратегийн зорилт 6:** Танхимын засаглал, менежментийг сайжруулах, дотоод хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нөөцүүдийг бэхжүүлэх

**1. Бизнесийн орчныг сайжруулахад бизнес эрхлэгчдийн оролцоог хангах, төр хувийн хэвшлийн хэлэлцлийн тогтолцоог бүрдүүлэх стратегийн зорилгыг хангах хүрээнд**

- 1.1 УИХ-ын тамгын газар Засгийн газрын хэрэг эрхлэх газартай хамтын ажиллагааны санамж бичгүүдийг байгуулах замаар төрийн хувийн хэвшлийн хэлцэл, түншлэлийг шинэ шатанд гаргах
- 1.2 Төрийн яам агентлагууд, бизнесийн төлөөллийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллагуудтай бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх, хороод, зөвлөл, ажлын хэсэг дэх бизнес эрхлэгчдийн болон танхимын оролцоог хангах
- 1.3 Бодлогын өмгөөллийн чиглэлээр бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах гол механизм болох танхимын дэргэдэх зөвлөлүүдээр дамжуулан салбаруудын бодлогын өмгөөллийн хэрэгцээг тодорхойлон, түүний дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- 1.4 Тогтвортой хөгжлийн зорилт, Ногоон хөгжлийн бодлогын үзэл баримтлалыг бизнес эрхлэгчдэд түгээх, энэ чиглэлээр төр, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийнхэнтэй үр дүнтэй хамтран ажиллах
- 1.5 Бизнес, эдийн засагтай холбоотой гарч буй аливаа хууль, тогтоол, бодлого шийдвэрүүдэд хувийн хэвшлийнхний санал бодлыг тусгуулах, энэ чиглэлээр хийсэн ажлыг үр дүнг тооцож эргэх холбоотой байх

**2 Бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын бичиг баримтыг боловсруулах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, сайжруулах, бүх шатанд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах стратегийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд**

- 2.1 Хуулийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн үр нөлөө үр дүнг гаргахад шаардлагатай судалгаа мэдээлэл гаргах
- 2.2 Засгийн газар, УИХ-аар хэлэлцэгдэх хууль болон бодлогын баримт бичгүүдийг тогтмол бизнес эрхлэгчдэд мэдээлэх, тэдний саналыг нэгтгэн тусгуулах талаар санаачлагатай ажиллах
- 2.3 Бизнесийн хууль эрх зүйн ба бодлогын өмгөөллийн чиглэлээр хэлэлцүүлэг, арга хэмжээг тогтмол зохион байгуулах, хэлэлцүүгээс гарсан санал зөвлөмжийг боловсруулан зохих байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх
- 2.4 Олон улсын олон талт ба хоёр талт гэрээ хэлэлцээрүүд ба чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулах болон хэрэгжүүлэхэд бизнесийн төлөөллийг хангаж ажиллах
- 2.5 Гишүүд, бизнес эрхлэгчдийг шинээр гарсан хууль, эрх зүйн баримт бичгүүдтэй холбоотой мэдээллээр тогтмол хангах, зөвлөгөө өгөх
- 2.6 Танхимын бодлогын өмгөөллийн үйл ажиллагааг бизнес эрхлэгчид болон олон нийтэд тогтмол мэдээлэх, сурталчлах

**3 Гишүүд ба бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлэх, урамшуулах стратегийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд**

- 3.1 Танхимын бүтээгдэхүүн үйлчилгээг багцлах санааг хөгжүүлэх ба хэрэгжүүлэх, гишүүдэд хүргэх ажил үйлчилгээний чанарыг сайжруулахад шаардлагатай баримт бичиг, үйл явц ба зохион байгууллалтын өөрчлөлт хийх
- 3.2 Бизнес эрхлэгчдэд МҮХАҮТ-ын гишүүнчлэл ба үйл ажиллагааны талаар тогтмол сурталчлах, гишүүдийн тоог нэмэгдүүлэх
- 3.3 Гишүүд ба бизнес эрхлэгчдэд шаардлагатай гадаад, дотоод уулзалт, үзэсгэлэн яармаг, сургалт болон бусад арга хэмжээг тогтмол зохион байгуулах, мэдээллийг тогтмол хүргэх
- 3.4 Олон улсын болон хөрш орнуудад зохион байгуулагдах үзэсгэлэн яармаг бусад арга хэмжээнд гишүүд бизнес эрхлэгчдийг өргөнөөр оролцуулах
- 3.5 Зураасан код, оюуны өмч, ата карней гэх мэт танхимын үндсэн үйлчилгээтэй холбоотой асуудлуудаар талаар тогтмол зөвлөгөө мэдээлэл өгөх
- 3.6 Жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд сурталчлах үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ зах зээлд нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх
- 3.7 Бизнес эрхлэгчид болон гишүүн байгууллагуудын чадавхийг сургалтын хэрэгцээ шаардлагыг судалсны үндсэн дээр бизнесийн ба мэргэжлийн сургалтуудыг чанартай, хүртээмжтэй явуулах,
- 3.8 Гишүүн байгууллагуудын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- 3.9 Ногоон хөгжил, цэвэр үйлдвэрлэлийг бизнес эрхлэгчдэд таниулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх төрөл бүрийн сургалт, сурталчилгааны арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- 3.10 Арбитр, эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны хамрах хүрээг өргөжүүлэх, хэрэг маргааныг шуурхай шийдвэрлэх, байгууллага, иргэдэд үзүүлэх эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээг өргөжүүлэх
- 3.11 Бизнесийн цуврал гар авлагуудыг шинэчлэх, шинээр шаардлагатай гарын авлагуудыг гаргах

**4. Бизнесийн бүх талын хамтын ажиллагааг хангах, тогтвортой сүлжээг хөгжүүлэх, талуудын харилцан ашигтай түншлэлийг бэхжүүлэх стратегийн зорилгын хүрээнд**

- 4.1 Олон улсын болон бүс нутгийн худалдааг дэмжих байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, донор байгууллагуудын төсөл хөтөлбөрт хамрагдах талаар санаачлагатай ажиллах, зангиагүй уулзалт, видео конференц зэрэг арга хэмжээг зохион байгуулах
- 4.2 Монгол Улсаас гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Өргөмжит консулууд ба Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудтай явуулах хамтын ажиллагааг идэвхжүүлэх

- 4.3 2016 онд эхлүүлсэн их дээд сургуулиудтай судалгааны чиглэлээр эхлүүлсэн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, судалгааны шинэ санааг хөгжүүлэх
- 4.4 Салбар танхимуудын үйл ажиллагаа болон орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилго бүхий “Chamber bus”, “Entrepreneur challenge” зэрэг шинэ, шинэлэг арга хэмжээнүүдийг зохион байгуулах
- 4.5 Дэлхийн ЭКСПО, Хөх хотын ЭКСПО болон улсын томоохон арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахад оролцох
- 4.6 МҮХАҮТ, ГХАҮТХ-ны хамтын ажиллагааны нэмүү өртгийн сүлжээг өргөжүүлэх, бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- 4.7 Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах
- 4.8 Компаний нийгмийн хариуцлага, авлига ба бизнесийн зарчмууд, хүүхдийн эрх ба бизнесийн зарчмуудыг нийгэм ба бизнес эрхлэгчдийн дунд түгээн дэлгэрүүлэх, энэ чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах
- 4.9 Олон улсын худалдааны төв /ITC/ -тэй хамтран танхимын гүйцэтгэлийг сайжруулах PIRM төслийг хэрэгжүүлэх

**5 Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөнд мэдрэмжтэй хандаж гишүүд, бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг үнэ цэнэтэй мэдлэг, мэдээллээр хангах стратегийн зорилгыг хангах хүрээнд**

- 5.1 Бизнесийн орчны талаар тогтмол явуулдаг судалгааны арга аргачлалыг олон улсын түвшинд нийцүүлэн шинэчлэн явуулах, судалгааны үр дүнг танилцуулах ажлыг өргөн хүрээнд өгөөжтэй явуулах
- 5.2 Бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг эдийн засаг, бизнесийн холбогдолтой төрөл бүрийн мэдээллээр хангах үйл ажиллагааг өргөжүүлэх
- 5.3 Танхимаас үзүүлдэг бүх төрлийн үйлчилгээ, аж үйлдвэрийн салбаруудын мэдээ, мэдээллийг цаг алдалгүй, тогтмол түгээх
- 5.4 Бүтээгдэхүүний гадаад ба дотоодын зах зээлийн судалгааг бизнес эрхлэгчдийн хэрэгцээнд тулгуурлан явуулах, түүний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх
- 5.5 Танхимын хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан бизнес эрхлэгчдийг мэдлэг мэдээллээр тогтмол хангах
- 5.6 Бизнесийн орчны судалгаа, мэдээллийг тогтмол цуглуулж, мэдээллийн сан үүсгэн тогтмол шинэчилж байх

**6. Танхимын засаглал, менежементийг сайжруулах, дотоод хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, нөөцүүдийг бэхжүүлэх стратегийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд**

- 6.1 Танхимын удирдах зөвлөл, тэргүүлэгчдийн хурлын тогтмол үйл ажиллагааг хангах, гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах, эргэх холбоог бэхжүүлэх
- 6.2 ISO9001:2015 чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх аждыг дуусгаж, баталгаажуулалт хийлгэх
- 6.3 Байгууллагын дотоод үйл ажиллагааны автоматжуулалт болон гишүүдийн мэдээлэл, бүртгэл, хяналтын системийг үр дүнтэй бүрэн нэвтрүүлэх, ашиглах
- 6.4 Экспертизийн үйлчилгээнд ISO17020 Хөндлөнгийн хяналтын олон улсын стандартыг үр дүнтэй нэвтрүүлэх
- 6.5 Танхимын маркетингийн бодлогыг сайжруулах, хэрэглэгчийн ба гишүүдийн сэтгэл ханамжийг хэмжиж үйл ажиллагаагаа сайжруулах суурь болгон хэвшүүлэх
- 6.6 Хүний нөөцийн бодлогыг тодорхойлох
- 6.7 Хүний нөөцийн мэдлэг ур чадварын шаардлагыг тогтоож, сургалтын хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- 6.8 Өөрийн удирдлагат багууд (SMT)-ыг ажиллуулах
- 6.9 Харилцаа холбоо, техник технологи, нөөцийн сайжруулалтыг хийж Виртуаль танхим болох арга хэмжээг авч хэрэгжүүлэх